


**ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН АВЛИГЫН ЭСРЭГ 2024 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ШИНЭЧИЛСЭН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН**

д/д	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Биелэлт
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	1.1. Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг а/ байгууллагын абан ёсны цахим хуудас; б/сошиал сувгууд; в/дотоод сүлжээ; г/хэвлэл мэдээллийн хэсэгсэл; д/мэдээлэл сурталчилгааны самбар, лед дэлгэц, е/бусад (салбар байгууллагууд) хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх;	-Тогтмол шинэчлэн, тогтвортой байршуулсан байх; -Түгээсэн, хүрсэн үр дүнгийн талаар салбар хариуцсан ажилтанд тухай бүрт тайлагнадаг байх; -Харъяа нэгжүүдийг нэгэн зэрэг хамруулж, үр дүнг нэгтгэн тайлагнаж хэвших; - Тайланд холбогдох нотломжийг хавсаргах.	Төвийн гадаа болон дотор байрлах самбарт 5 төрлийн зурагт хуудас байршуулсан. Мэдээллийн дэлгэцээр 2 төрлийн шторкийг долоо хоногт 2 удаа тогтмол гарган олон нийтэд хүргэдэг. Төвийн цахим хуудсанд /www.hdc.gov.mn/ Авлигийн эсрэг цэс ажиллуулан АТГ-аас гаргасан сурталчилгааны материалуудыг байршуулсан. Одоогоор 3 төрлийн шторк, 5 төрлийн зурагт хуудас байршсанг нийт хүн орж үзсэн байна. Төвийн фэйсбоок хуудсаны профайл хэсэгт 110 утасны мэдээлэл байнга байршиж байна. 2024 оны 1 сарын 1-нээс 3 төрлийн шторк, 5 төрлийн зурагт хуудас фэйсбоок хуудсанд байршуулсан.



		1.2. Өөрийн байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргадаг ном гарын авлага, сэтгүүл, иргэдэд тараадаг хэвлэмэл материал зэрэгт авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчилан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигын мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталталчлах	-Мэдээллийг Авлигатай тэмцэх газраас буюу баталгаат эх сурвалжаас авсан байх; -Байгууллагын эрх хэмжээний хүрээнд иргэд олон нийт рүү чиглэсэн хэвлэмэл материалд оруулсан байх; -Үр дүнг тайлагнасан байх; -Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших.	Төвөөр үйлчлүүлж байгаа иргэд, хэрэглэгчийн самбарт АТГ-аас боловсруулан гаргасан суртчилгааны материал, хэвлэмэл хуудас, авлигын мэдээлэх 110 дугаарыг тогтмол байршуулж мэдээллээр ханган ажилладаг. Төрөлжсөн, төв эмнэлэгийн (58), Өрх, тосгоны эрүүл мэндийн нэгдсэн төв (188), Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага (122), Магадлан итгэмжлэлийн шинжээч (137) нарын телеграммын нэгдсэн группт авлигын мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчилан ажиллаж байна.
--	--	---	---	--

		1.3. Өөрсдийн байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий 2-оос доошгүй видео контент бүтээж, олон нийтэд хүргэсэн байх	-Авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх; Авлигын мэдээлэх 110 дугаарын утсын сурталчилсан байх;-Олон нийтэд түгээсэн байх.	🚩 Жил бүр зохион байгуулагддаг төгсөлтийн дараах Үндсэн мэргэшлийн сургалтын элсэлтийн шалгалтын үеэр: - 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс Үндсэн мэргэшлийн элсэлтийн шалгалтын бүртгэл эхэлсэнтэй холбоотой 21 аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга, хүний нөөцийн мэргэжилтэн нартай цахим уулзалт зохион байгуулж нэгдсэн мэдээллээр хангахын зэрэгцээ тулгамдаж буй асуудлаар санал солилцсон. - Улсын төсвийн санхүүжилтээр үндсэн мэргэшлийн сургалтад суралцуулах эмнэлгийн мэргэжилтнийг сонгон шалгаруулахад анхаарах зүйлс, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь чиглэлээр төвийн Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын албаны ахлах мэргэжилтэн илтгэл танилцуулсан. - Мөн тус төвийн ЭБАТ-ыг оролцуулан “Хахууль авах гэмт хэргийн хохирогч болохоос сэргийлнэ үү”, - “Авлигийн талаар мэдээллээ 110 дугаарт өгнө үү” богино хэмжээний видео бэлтгэн рийл, стори, пост хэлбэрээр төвийн цахим хуудас, мэдээллийн дэлгэцээр дамжуулан олон нийтэд хүргэн сурталчиллаа. - Дээрх сэдвүүдээр мөн зурагт хуудас бэлтгэн түгээсэн.  0-02-08-ca50dda2c3 fb533e29760bd4475
2	Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийг бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх	2.1. “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг журам”-ыг хэрэгжүүлэх;	-Журамд заасны дагуу өөрийн байгууллагын үйл ажиллагааны 1-ээс доошгүй чиглэлд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэхээр сонгосон байх; - Сонгон чиглэлд олон нийтийг хяналтыг хэрэгжүүлэх сонгон шалгаруулалт зарласан байх;	🚩 Засгийн газрын 2021 оны “Журам батлах тухай” 109 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн байгууллага албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ын хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд: - Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийн ил тод нээлттэй байдлыг ханган https://www.infoshilendans.gov.mn сайтад дараах мэдээллийг байршуулсан. Үүнд:

			-Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэн тайлагнах; -Үр дүнд суурилсан арга хэмжээг зохион байгуулсан байх.	✓ 2024 оны батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт; ✓ Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл; ✓ 2024 оны төсөвт орсон нэмэлт өөрчлөлт; ✓ 2024 оны төсөв, гүйцэтгэл-Хөтөлбөр, зориулалт; ✓ Байгууллагын батлагдсан тоонд орсон өөрчлөлт зэрэг сар бүр тавих мэдээллүүд; ➢ 2024 оны ХАА-ны төлөвлөгөө; ➢ Байгууллагын батлагдсан төсөв; ➢ Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт зэрэг ажил тавих мэдээллүүд; ✓ Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл; ✓ Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгийн үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ; ✓ Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт; ✓ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8,9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл; ✓ Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн шийдвэр; ✓ Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгийн үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ; ✓ Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн зэрэг тухай бүр тавих мэдээллүүд зэрэг орсон. Шилэн дансанд 2024 оны 4-р улирлын байдлаар нийт 28 төрлийн 50 мэдээ мэдээллийг байршуулж олон нийтийн хяналт хийх боломжийг ханган ажилласан. - Албан тушаалтан хандив авах, давхар ажил эрхлэх, төлбөр авах, төлөөлөл хэрэгжүүлэх зэрэг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг мөрдөх: Энэхүү арга хэмжээний хүрээнд 2024 оны 12 сарын байдлаар ЭМХТ-д ажиллаж буй 81 албан хаагчид давхар ажил эрхлээгүй бөгөөд хандив, төлбөр тусламж авалгүй хориглолт, хязгаарлалтын зөрчилгүй ажиллаж байна.
--	--	--	--	--

			- Албаны үүргээ хэрэгжүүлэх явцад үл ойлгогдохуйц, нөхцөл байдал үүсгэсэн, ашиг сонирхлын зөрчилтэй нөхцөл байдалд шийдвэр гаргасан, үйл ажиллагаа эрхэлсэн эсэх чиглэлээр: Мөн төвийн хэмжээнд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл, зөрчил үүссэн эсэх тухай давхардсан тоогоор 24 мэдэгдэл, тайлбар гаргасан. Эдгээр мэдэгдэл, тайлбарт ямар нэг зөрчил үүсээгүй ба хориглолт, хязгаарлалтыг аливаа хэлбэрээр зөрчөөгүй ажилласан.
	2.2. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх	-Салбар бүрт үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудын нэгдсэн судалгааг гаргасан байх; Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр иргэний нийгмийн ороолцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ авч ажилласан байх; -Үр дүнг тооцож , тайлагнасан байх	✚ Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлийн хүрээнд ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/74 дүгээр тушаалаар батлагдсан Тусгай зөвшөөрлийн орон тооны бус шинжээчдийг сонгон шалгаруулах удирдамж батлагдан шинжээч сонгон шалгаруулах үйл ажиллагааг 2024.07.02-ны өдөр зохион байгуулж сонгон шалгаруултад тэнцсэн 17 шинжээчийг ЭМС-ын 2024 оны А/366 дугаар тушаалаар баталгаажуулж, гэрээ байгуулсан. Шинээр томилогдсон тусгай зөвшөөрлийн шинжээч нарт ЭМХТ-ийн захирлын батлагдсан удирдамж, хөтөлбөрийг батлуулж 2024 оны 08 сарын 07-нд танхимаар, 08 сарын 15-нд цахимаар, нийт 2 удаагийн сургалт зохион байгууллаа.  Сургалтад 17 шинжээч хамрагдсан ба тусгай зөвшөөрлийн талаарх хууль эрх зүй, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийн тухай, шинжээчийн ёс зүй, төслийн болон ажлын байрны дүгнэлт гаргах арга зүйн талаар мэдээллийг өгч ажилласан. - Мөн Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн шинжээчдийн ур чадварыг чадавхжуулах сургалтыг төвийн захирлын батлагдсан удирдамж, хөтөлбөрийн дагуу 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Сургалт нь Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн шинжээчдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бодлого, шийдвэр түүний хэрэгжилтийн талаарх мэдлэгийг дээшлүүлж, үнэлгээ-дүгнэлт хийх арга зүйгээр ханган, магадлан итгэмжлэх үйл ажиллагааны чанар үр дүнг

			сайжруулах зорилготой юм. Сургалтад ЭМЯ, ЭМЯ-ны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороо, Авлигатай тэмцэх газар, Чанарыг иргэн бүрийн эрүүл мэндэд ТББ, магадлан итгэмжлэлийн шинжээч, НЭМҮТ, Эдумед консалтинг ХХК, Америкийн магадлан итгэмжлэлийн нийгэмлэгийн олон улсын үйл ажиллагаа хариуцсан захирал Др. Саад нар хамтран ажилласан. Сургалтаар Магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, шинэчлэл, шинжээчийн ёс зүйд анхаарах асуудал, үйлчүүлэгчийн аюулгүй байдлын олон улсын туршлага, магадлан итгэмжлэлийн үнэлгээний арга зүй, үнэлгээний явц, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийн талаар шинжээчдийг шинэ мэдээлэл, нэгдсэн арга зүйгээр хангасан. 	Магадлан итгэмжлэлийн шинжээчийг чадавхижуулах 2 удаагийн сургалтад нийт 153 шинжээч хамрагдлаа.
	2.3. Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах	-2024 онд төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар иргэд, олон нийтэд тогтмол ойлгомжтой байдлаар тогтмол мэдээлэх; -Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой иргэд, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээг нэмэгдүүлэх;	🇮🇷 2024 онд төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг байгууллагын https://hdc.gov.mn/- Шилэн данс хэсэгт болон https://shilendans.gov.mn хуудсанд сар бүр байршуулж байна.	
	2.4. Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн	-Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал, чирэгдэл, холбоотой гомдол,	🇮🇷 Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал, чирэгдэлтэй холбоотой гомдол, мэдээллийг тогтмол гаргаж 7 хоног бүрийн даваа гаригт Удирдлагын шуурхай хуралд	

		гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж хэвших	мэдээллийн судалгааг тогтмол гаргаж тайлагнах; -Хуулийн хүрээнд шуурхай, бодитой шийдвэрлэж хэвших; -Иргэд, олон нийтээс Байгууллагын үйл ажиллагаа, хүнд суртал чирэгдэл, холбоотой гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх.	танилцуулж хэрэгжилтийг ханган ажилладаг. Мөн ЭМЯ-ны ТЗУГ-т улирал бүр тайлагнаж байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар иргэдээс ирүүлсэн 16 өргөдөл гомдлыг тухай бүр удирдлагад танилцуулан шуурхай шийдвэрлэж хариуг хүргүүлэн ажиллаж байна. ХШҮДАА-наас өргөдөл гомдолтой холбогдох асуудлыг тухай бүр шуурхай шийдвэрлэн хэрэгжилтийг ханган ажиллах зөвлөмжийг хүргүүлдэг.
3	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах	3.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр тухайн байгууллагаас цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулах	- Нэвтрүүлсэн цахим үйлчилгээний чанар хүртээмжийн талаар иргэд олон нийтээс судалгаа, санал асуулга авах; - Дүн шинжилгээ хийж , үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх; - Хэрэгжилтийг тайлагнах,	✚ Байгууллагад нэвтрүүлсэн “Цахим үйлчилгээний чанар, хүртээмж”-ийн талаар иргэд олон нийтээс судалгаа, санал асуулга авах” арга хэмжээний хэрэгжилтийг хангах чиглэлээр “Цахим үйлчилгээний чанар хүртээмжийн судалгаа”-ны 10 асуумжийг боловсруулж бүх шатны төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаас “Google forms”-оор 2024.10.29-нөөс 11.27-ны өдрүүдэд 172 үйлчлүүлэгчээс авч судалгааны дүнг нэгтгэн гаргаж Удирдлагад танилцуулсан. Судалгааны үр дүн, үйлчлүүлэгчийн санал хүсэлтийн дагуу зохион байгуулах ажлын саналыг 2025 оны төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг ханган ажиллана.
		3.2. Байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулж, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх;	-Албан хаагчидтай холбогдуулан ирүүлсэн авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн хэвших; Албан хаагчдыг авлига, ашиг сохирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг байгууллагын үйл ажиллагаанд тохируулан эрсдэлийг тодорхойлсон байх; Эрсдэлийг арилгах хэмжээнд дотоод хяналтын үйл ажиллагааг зохион байгуулсан байх;	✚ Албан хаагчидтай холбогдуулан ирүүлсэн авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол ирээгүй байна.




Үндсэн мэргэшлийн элсэлтийн шалгалтад бүртгүүлэгчдийн анхааралд

Үндсэн мэргэшлийн сургалтын элсэлтийн шалгалт өгөх эмнэлгийн мэргэжилтэнд зориулж Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран “**Хахууль авах гэмт хэрэг, түүний хохирогч болохоос урьдчилан сэргийлэх нь**” сэдэвт цахим сургалтыг 9 дүгээр сарын 13-ны өдрийн 15:00 цагаас зохион байгуулна. Сургалтад идэвхтэй хамрагдахыг урьж байна.

ZOOM ID: 219 827 7941
PASSCODE: 202409

“Анагаах ухааны их, дээд сургуулийг 2024 онд төгсөж буй төгсөгчдөөс мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн шалгалт”, “Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн зэрэг олгох шалгалт”, “Үндсэн мэргэшлийн сургалтын 2024-2025 оны хчизэлийн жилийн элсэлтийн шалгалтын комисс”-ын

				бүрэлдэхүүнд томилогдсон ЭМЯ-ны дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөл, мэргэжлийн нийгэмлэг, холбооны гишүүд болон төвийн захирлын тушаалаар батлагдсан шалгалтын комиссын бүрэлдэхүүнд “Авлигын гэмт”, “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь”, “Ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэхийг илэрхийлсэн мэдэгдэл, тайлбар гаргах нь” сэдэвт сургалтыг АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран зохион байгуулж давхардсан тоогоор 140 гаруй хүнийг хамрууллаа. Комиссын бүрэлдэхүүн нь шалгалтад хөндлөнгийн хяналтаар ажиллаж тайланг тухай бүр Удирдлагын шуурхай хуралд танилцуулж, тайлагнан ажилладаг.
		3.3. Тухайн байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр шинэ санал, санаачилга гарган арга хэмжээг хэрэгжүүлэх	Төлөвлөгөөний 1.1-3.2-дах хэсэгт заасан арга хэмжээтэй агуулгаараа давхцахгүй байх; Байгууллагын үйл ажиллагаа, үзүүлж буй төрийн үйлчилгээний онцлогт тохируулан зохион байгуулсан арга хэмжээний үр дүнг олон нийтэд мэдээлсэн байх; Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж, албан бичгийн хэрэгжилтийг хангасан байх;	Төвийн албан хаагчдад зориулсан Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2 удаагийн сургалтыг танхимаар болон цахимаар зохион байгуулсан. Мөн Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтээс зохион байгуулсан УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 04 сарын 02-ны өдрийн “Журам, маягт жагсаалт шинэжчлэн батлах” 5 дугаар тогтоолыг танилцуулах сургалтыг 7 албаны дарга, ахлах нягтлан бодогчийг оролцуулан ERP цахим систем, VIBER группт байршуулан танилцуулж мэдээллээр хангасан. 2024 оны 06 сарын 23,24-ний өдрүүдэд АТГ-ын УССГХ, ЭМЯ-ны хамтран зохион байгуулсан “Сургагч багш” бэлтгэх сургалтад хамрагдаж нэг албан тушаалтан сургагч багшаар бэлтгэсэн. 
4	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх	4.1.Авлигатай тэмцэх газраас дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг тусгасан байдал;	-Санал тусгасан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	Энэ чиглэлээр санал авахаар ирүүлээгүй байна.

		4.2. Эрүүл мэндийн цахим шилжилтийг эрчимжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх;	Шударга байдлын үнэлгээний оноо нэмэгдсэн байна.	▪ Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой үүссэн тохиолдол, эрсдэлийг бүртгэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах “Тохиолдол, эрсдэлийн мэдээллийн нэгдсэн сан” нь 2022 оны 2 дугаар сараас туршилтын журмаар 37 эрүүл мэндийн байгууллагын хүрээнд ажиллаж эхэлсэн ба 2023 оны 1 дүгээр улирлаас улсын хэмжээнд бүх эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээтэй холбоотой үүссэн тохиолдол, эрсдэл, сайн туршлагыг санд бүртгэж эхэлсэн. 2024 оны 11 сарын байдлаар тус санд 2811 эрүүл мэндийн байгууллага, 6734 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд бүртгэлтэй байгаа ба 3780 тохиолдол, 1420 эрсдэл, 45 сайн туршлага, 22 эрх зүйн баримт бичиг, 11 мэдээ мэдээлэл, цаг үетэй холбоотой 11 сэрэмжлүүлэг байршуулан ажиллаж байна. ▪ Гааль, татвар санхүү мэдээллийн төв, ЭМЯ-тай хамтран license.mn цахим системээр эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг нэвтрүүлдэг болгохоор шаардлагатай нэмэлт тохируулгуудыг захиалан хийлгүүлсэн. Тухайлбал ТЗ-ийн хүсэлт гаргах байгууллагын оруулах мэдээлэл, хур системээс татаж харах мэдээлэл болон байнгийн шалгуур, шийдвэрлэлтийн үе шат гэх мэт. Системийг туршилтын журмаар ашиглаж эхэлсэн ба цаашид үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлэхэд бэлэн болсон. ▪ Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэлийн сан программ хангамжид нийт 67959 ажилтан бүртгэл үүсгэсэн байна. Эрүүл мэндийн 18568 ажилтан зөвшөөрөл сунгуулах хүсэлт гаргаж, 13573 ажилтны хүсэлтийг хүлээн авч хянан 13018 ажилтны хүсэлтийг Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталгаажуулан шийдвэрлэсэн. Мөн 246 гадаадын эмнэлгийн мэргэжилтний Монгол улсад эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг шийдвэрлэн олгосон. Эрүүл мэндийн ажилтны тоо мэдээнд үнэлэлт дүгнэлт хийх, боловсруулалттайгаар олон нийтэд танилцуулах зорилгоор tableau программыг лицензийн эрхтэйгээр суурилуулан Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэлийн сантай сервис холболтоор шууд холболт хийсэн. Одоогоор 10 төрлийн тайлан мэдээг 1313.mn сайтад real time горимоор гаргаж байна. Эдгээрээс гадна доорх хөгжүүлэлтүүдийг хийж гүйцэтгэлээ:
--	--	--	---	---

				Хур системээс иргэний цээж зураг, иргэний үнэмлэхний дугаарыг татдаг болсон. Танхимын шалгалтад иргэний үнэмлэхээр бүртгүүлэн нэвтрэх хөгжүүлэлт хийсэн. Шалгалтад хамрагдагчын давхар лог бүртгэлийг харуулдаг болсон. Шалгалтын нэгдсэн дүн, үнэлгээг нэвтрэлтгүйгээр hdc.gov.mn сайтад шууд харуулдаг болсон. Эрүүл мэндийн салбарын цогц шинэчлэлийн хүрээнд 2023 онд салбарын болоод салбар дундын хууль тогтоомж шинээр болон шинэчлэн батлагдаж, мөн нэмэлт, өөрчлөлтүүд орсон. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”, Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 51 дүгээр тэмдэглэлийн XXIV.4.2 дахь хэсэг, Ерөнхий сайдын 2023 оны 12 сарын 21-ний өдрийн 206 дугаар захирамж, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/177 дугаар тушаалд тус тус үндэслэн эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэх арга хэмжээний хүрээнд дараах цогц үйл ажиллагааг зохион байгуулсан. Үүнд: -Эрүүл мэндийн салбарын хууль эрх зүйн шинэчлэл болон мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, иргэдэд учрах чирэгдлийг бууруулах төрөөс баримталж буй бодлого чиглэлийг эрүүл мэндийн салбарын нийт ажилтан албан хаагчдад танилцуулж, салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн хөгжлийн төв нь Эрүүл мэндийн яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран 2024 оны 04 дүгээр сарын 25-наас 05 дугаар сарын 25-ны өдрүүдэд “Нийгмийн эрүүл мэнд тэргүүлэх чиглэл болох нь, Эрт илрүүлгийн дүн”, “Төрийн бүтээмжийн сэргэлт -Монгол Улсын цахим шилжилтийн бодлого”, “Эрүүл мэндийн салбарын цахим шилжилт” , “Үйлчилгээний стандартыг хэрэгжүүлэх нь”, “Эрүүл мэндийн даатгалын шинэчлэлийн бодлого, хэрэгжилт, тарифын өөрчлөлт”, “Эрүүл мэндийн салбарын санхүүжилт, дүгнэлт, аудитын зөрчил”, “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар авч хэрэгжүүлсэн арга, хэмжээ, үр дүн, цаашид тавих зорилт -аймгийн түвшинд” сэдэвт сургалтыг 21 аймаг, нийслэлийн -4 дүүргийн нийт 24 эрүүл мэндийн байгууллагын, 10,883 эрүүл мэндийн ажилтанг хамруулсан.
--	--	--	--	---

			Сургалтаар эрүүл мэндийн салбарын эрх зүйн орчны шинэчлэл болон цахимжилттай холбоотой эрх зүйн баримтууд мэдээллийн аюулгүй байдлын талаар мэдлэг мэдээлэл олгож эрүүл мэндийн салбарын нийт албан хаагчид нэгдсэн нэг ойлголттой боллоо. - ЭМС-ын 2024 оны А/113 дугаар тушаалаар төвийн бүтцэд үйл явуулж байгаа Эрүүл мэндийн мэдээллийн албыг Мэдээлэл технологийн алба болгон өөрчлөн зохион байгуулж чиг үүргийн дагуу эрүүл мэндийн цахим шилжилтийг эрчимжүүлэхэд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд: ▪ Эрүүл мэндийн мэдээллийн тогтолцоонд мөрдөх анхан шатны бүртгэл тайлангийн маягт ЭМС-ын 2019оны А/611 тушаалыг шинэчлэх, цаасан маягтыг цахим маягт болгох, метадата сан үүсгэх; ▪ Эрүүл мэндийн төрөлжсөн мэдээллийн сан буюу Health ESB системийг хүлээж авах; ▪ Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудаас лавлагаа шатлалын эмнэлгийн эмчийн үзлэгийн цаг захиалах боломжийг Health ESB системд нэмэлтээр хөгжүүлэхээр ажиллаж, холбогдох сервисүүдийг хөгжүүлэн, туршилт хийж байна; ▪ Эм, эмнэлгийн хэрэгслийн цахим мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх иж бүрэн программ хангамжийг нэвтрүүлэх ажлын хүрээнд Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын нэгдсэн системийг хөгжүүлж зарим модулиудад туршилт хийн анхан шатны эрүүл мэндийн байгууллагад ашиглагдах эмнэлгийн системийн судалгааг хийсэн; ▪ Сургуульд суурилсан эрт илрүүлгийн цахим программ хангамжийг боловсруулан нэвтрүүлэх; ▪ Эрүүл мэндийн статистик мэдээллийн 1313.mn цахим хуудсыг хөгжүүлж, эрүүл мэндийн салбарын статистик үзүүлэлтүүдээр мэдээлэл боловсруулан мэдээллээр хангах; ▪ Телемедициний тусламж үйлчилгээний үйл ажиллагааг зохицуулалтыг боловсронгуй болгох; ▪ Орон эрүүл мэндийн байгууллагуудын удирдлагуудад тоон гарын үсэг нэгдсэн системд шилжүүлж, тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулсан. ▪ Төрийн мэдээлэл солилцооны нэгдсэн сүлжээнд холбогдон ҮДТ-ийн хамгаалттай бүсэд байршдаг Health ESB системтэй холбогдсон; ▪ Нийтийн төвтэй хамтран хувийн хэвшлийн эрүүл
--	--	--	--

				мэндийн байгууллагуудын дарга нар болон мэдээлэл технологийн мэргэжилтнүүдэд онц чухал дэд бүтэцтэй байгууллагын жагсаалтад оруулах талаар уулзалт, “Мэдээллийн аюулгүй байдал” сэдэвт сургалтыг тус тус зохион байгуулсан. ▪ МАБ-ын аудит хийлгэж, өгсөн зөвлөмжийн дагуу ажлуудыг төлөвлөн хэрэгжилтийн тайланг ТЕГ-ын МАБГ-т хүргүүлсэн. ▪ Эрүүл мэндийн сан үүсгэхээр ҮДТ- дээр 7 физик сервер байршуулан сүлжээний болон дүрмийн тохиргоог хийсэн. ▪ Эрүүл мэндийн цахим шилжилтийг эрчимжүүлэх нь сэдэвт сургалтыг Нийслэл, орон нутгийн бүх Эрүүл мэндийн байгууллагын 10,804 эмч, ажилтнуудад зохион байгуулж, мэдлэг мэдээллийг олгосон.
		4.6. Эрүүл мэндийн яамны худалдан авах ажиллагааны авлигын эрсдэлийг бууруулах зорилгоор энэ чиглэлийн сургалтад албан хаагчдыг хамруулж, үнэлгээний хорооны гишүүдийн тоог нэмэгдүүлэх;	Тайланд нотломжийг хавсаргасан байх	“ХААХ” ТББ-ын Худалдан авах ажиллагааны АЗ сертификат олгох сургалтад 14 албан хаагчийг хамруулан сургасан. 7 албан хаагч шалгалтаа өгч, гэрчилгээ авсан. 7 албан хаагч дахин шалгалтад орно. 
5	Байгууллагын авлигын эрсдэлийг бууруулах, шударга байдлын үнэлгээг нэмэгдүүлэх зорилгоор зайлшгүй тусгай хэрэгжүүлэх арга хэмжээ (АТГ-ын 2024.06.19-ний өдрийн 08/10675 дугаар албан бичгийн дагуу тусгайлан хэрэгжүүлэх арга хэмжээний нэмэлт)	5.1. Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/406 дугаар тушаалаар батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм”-ийг Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд нийцүүлэн шинэчлэн баталж мөрдүүлэх;	Шударга байдлын үнэлгээний оноо нэмэгдсэн байна.	🇮🇪 2024 оны 6 сарын 24-ний өдрийн төвийн нийт албан хаагчдын хурлаар “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”-ийн хүрээнд “Ёс зүйн дэд хороо”-г шинэчлэн сонгосон. Ёс зүйн дэд хороо нь 7 хүний бүрэлдэхүүнтэй бөгөөд Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/406 дугаар тушаалаар батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм”, “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ”-г нийт албан хаагчдад сурталчлан таниулах ажлыг төлөвлөн байгууллагын дотоод сүлжээ, ухаалаг дэлгэцээр 21 мэдээ, мэдээлэл бэлтгэн нэвтрүүлж, ёс зүйн 6 сургалтыг зохион байгуулан албан хаагчдад зөв харилцаа, хандлага, ёс зүйг баримтлан дээдлэх мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн үр дүнтэй сургалт боллоо.

		5.3. “Зөвшөөрлийн цахим систем”-д эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг бүрэн нэвтрүүлэх;	Шударга байдлын үнэлгээний оноо нэмэгдсэн байна.	🇮🇲 Гааль Улсын хэмжээнд тусгай зөвшөөрлийг license.mn цахим систем 2024 оны 07 сарын 01 нээс ашиглалтад орсонтой холдогдуулан, Эрүүл мэндийн яам, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Эм эмнэлгийн хэрэгсэл хяналт зохицуулалтын газар, 21 аймгийн эрүүл мэндийн газрын тусгай зөвшөөрлийн салбар зөвлөл бүр өөрсдийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудын нэгдсэн бүртгэл мэдээллийг оруулдаг программ хөгжүүлэлтийн ажил хийгдэж нийт 4248 байгууллагын мэдээлэл нэгдсэн программд бүртгэгдсэн. ✓ License.mn сайтад 2024 оны 11 сарын байдлаар: Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, протез үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх, засвар үйлчилгээ эрхлэх -130 ✓ Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ эрхлэх – 1660 ✓ Эх барихын тусламж, үйлчилгээ эрхлэх – 30 ✓ Сэргээн засахын дагнасан тусламж, үйлчилгээ эрхлэх – 30 ✓ Сувилахуйн дагнасан тусламж, үйлчилгээ эрхлэх – 20 ✓ Мансууруулах бодис бүхий ургамал ашиглаж эм бэлтгэн найруулах -1 байгууллага бүртгэгдсэн байна. ✓ Түргэн тусламжийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл – 3 ✓ Эмнэлгийн яаралтай туслаж, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл – 4 тус тус бүртгэлтэй байна.
--	--	---	---	---